



Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн 225 дугаар тогтоолоор баталсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 4 дүгээр хавсралт

Хагас жил, улирлын үйл ажиллагааны тайлан /маягт 2/	
<p>Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй.</p>	
Тайлагнах хугацаа	2023 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс 2023 оны 6 дугаар сарын 30-ний өдөр
Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар	<p>Үнэт цаас гаргагчийн нэр: ХасБанк ХК УБГД: 9016001007 Үнэт цаасны код: MN00XAC05687 Утасны дугаар: +976-75771888</p>
Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр	Монголын хөрөнгийн бирж
Бизнесийн үйл ажиллагааны салбар	Банк, санхүү
Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг	1,052,700,000
Хагас жил, улирлын тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр	<p>Бэлтгэсэн: Г.Тамир /Санхүү удирдлагын газрын захирал/ Хянасан: Г.Эрдэнэбаяр /Санхүү хариуцсан захирал/</p>
1.	<p>Хагас жилийн болон улирлын санхүүгийн тайлан /хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана/ Санхүүгийн байдлын үзүүлэлт Орлогын тайлан Өмчийн өөрчлөлтийн тайлан Мөнгөн гүйлгээний тайлан</p> <p>2023 оны хагас жилийн санхүүгийн тайланг хавсаргав /Хавсралт №1/</p>
2.	<p>Хагас жилийн болон улирлын санхүүгийн тайланг хэлэлцэж, баталгаажуулсан төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх аудитын хорооны дүгнэлт</p> <p>2023 оны хагас жилийн санхүүгийн тайланг хөндлөнгийн хараат бус аудитор хянах ажил хийгдэж байна.</p>
3.	<p>Тайлант хугацаанд үнэт цаас гаргагчийн санхүүгийн үйл ажиллагаанд нөлөөлсөн гадаад, дотоод хүчин зүйлс, санхүүгийн тайлангийн шинжилгээ, орлого, зарлага, ашгийн үзүүлэлтүүдийг тооцож дүгнэсэн удирдлагын тайлан, дүгнэлт</p>

3.1.	Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/	<p>2023 оны эхний 6 сарын ХасБанкны татварын дараах цэвэр ашиг 62.2 тэрбум төгрөгт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 27%-р өслөө. Тайлант хугацааны нэгж хувьцаанд ногдох татварын дараах цэвэр ашиг (EPS) 59.1 төгрөг байна.</p> <p>Тайлант хугацаанд нийт актив 4,251 тэрбум, нийт пассив 3,710 тэрбум, өөрийн хөрөнгө 541 тэрбум төгрөгт хүрч, оны эхнээс 8.1%, 7.4%, 13.8% тус тус өслөө. Нийт зээл ба санхүүгийн түрээсийн багц оны эхнээс 23.9%-р өсч 2,544 тэрбум төгрөг, харилцах ба хадгаламж 0.2%-р өсч 2,422 тэрбум төгрөг, Олон Улсын санхүүгийн байгууллагуудаас татсан гадаад эх үүсвэр 288 сая ам.доллар (988.6 тэрбум төгрөгтэй тэнцэх)-т хүрч 37.3%-р нэмэгдсэн нь балансын өсөлтийг бүрдүүлэхэд гол нөлөө үзүүлсэн байна.</p> <p>Тайлант хугацаанд чанаргүй зээлийг бууруулах стратегийн хүрээнд чанаргүй зээлийг тогтмол бууруулж, нийт зээлийн багцын 2.9%-д хүргэлээ.</p>		
3.2.	Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт	Тусгайлан өөрөөр заагаагүй бол хувиар (%) илэрхийлэв	Байвал зохих	2023.06
		Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө болон эрсдэлээр жигнэсэн активын зохистой харьцаа	>12.5%	19.1%
		Өөрийн хөрөнгө болон эрсдэлээр жигнэсэн активын харьцаа	>12%	19.1%
		Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа	>25%	36.6%
		Гадаад валютын нээлттэй позиц болон өөрийн хөрөнгийн харьцаа (нэгж валютаар)	+/- 15%	4.4%
		Гадаад валютын нээлттэй позиц болон өөрийн хөрөнгийн харьцаа (нийт валютаар)	+/- 30%	4.7%
		Нийт томоохон зээлдэгчдэд олгох активын төвлөрлийн харьцаа	<300%	37.1%
		Том 10 харилцагчийн хадгаламж, харилцахын төвлөрлийн харьцаа	<25%	7.0%

3.3.	<p>Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчны нөлөөлөл, бүтээгдэхүүн, үйлчилгээний төрөл хэлбэрт гарч буй өөрчлөлт, дээрх өөрчлөлтөд компанийн зүгээс авч хэрэгжүүлж буй арга хэмжээний мэдээлэл</p>	<p>Тайлант хугацаанд Иргэдийн банкны зээл 26.0%, Байгууллагын банкны зээл 8.1%, Хаслизинг (санхүүгийн түрээс)-ийн багц 40.8% өссөн байна. Иргэдийн банкны өсөлтөд эмэгтэй бизнес эрхлэгчдийг дэмжих зээлийн өсөлт нөлөө үзүүлсэн байна. ХасБанк нь 2023 оны 2 дугаар улиралд “Таблет Банкинг” үйлчилгээг нэвтрүүлж, бичил-жижиг бизнесийн процессийг хялбарчилсан нь зээлийн үйл ажиллагаанд эерэг нөлөө үзүүлж байна. Харин Хаслизингийн хуьд Монгол улсын гадаад худалдаа, түүний тээврийн асуудал хэвийн горимруу шилжиж буйтай зэрэгцээд шинэ авто машин, механизмын худалдаа сайжирсан нь голлон нөлөөлсөн.</p> <p>Тайлант хугацааны оцног үйл явдал. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Эмэгтэй бизнес эрхлэгчдийг дэмжих зээлийг шинэчилж, харилцагчиддаа санал болгов. 2. Цалингийн хуримтлал болон онлайн цалингийн зээлийг зах зээлд нэвтрүүлэв. 3. Уур Амьсгалын Ногоон Сангаас 2 дахь удаагаа магадлан итгэмжлэгдээ. 4. Автомашин худалдан болон амьны орон сууцны зээл шуурхай зээлийн бүтээгдэхүүн зах зээлд нэвтрүүлэв. Энэ хүрээнд CENTURY 21-тэй хамтын ажиллагааны гэрээ байгуулж, мөн зээлийн төвийг шинээр байгуулав. 5. Олон улсын санхүүгийн байгууллагуудаас 105 сая ам.долларын эх үүсвэр оруулж ирэв. <p>Дэлгэрэнгүйг "ХасБанкны 2023 оны эхний хагас жилийн санхүү, үйл ажиллагааны тайлан"-с үзнэ үү.</p>
3.4.	<p>Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлого</p>	<p>Хавсралт №2</p>
4.	<p>Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй хэлцэл болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийгдэх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/</p>	
	<p>ТУЗ-өөс 2023 онд нийт 9 сонирхлын зөрчилтэй болон холбогдох этгээдийн хэлцлийг батламжилсан. Эдгээр бүх хэлцэл нь Банкны тухай хуулийн 17.9-д заасан шаардлага буюу банкны ердийн үйл ажиллагааны хүрээнд бусад этгээдтэй хийх хэлцлээс хөнгөлөлттэй нөхцөлгүй байх шаардлагыг хангасан болно. Банкны тухай хуулийн дагуу Банкны холбогдох этгээдэд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгийн тайланг улирал бүр гарган өөрийн вебсайтаар олон нийтэд мэдээлдэг болно. 6 сарын 30-ны байдлаарх Банкны холбогдох этгээдэд олгосон зээл болон зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгө дараах байдалтай байна:</p>	
5.	<p>Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор олон нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойших төслийн хэрэгжилтийн явц, татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан, мэдээлэл</p>	
	<p>Татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайланг хавсаргав. Хавсралт №3</p>	
6.	<p>Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл</p>	

	<p>Тус Банкны ТУЗ-ийн хараат бус гишүүн Эрик Версавел өөрийн хүсэлтээр албан тушаалаас чөлөөлөгдөх хүсэлт гаргасныг Хувьцаа эзэмшигчдийн 2023 оны 6 дугаар сарын 12-ны өдрийн ээлжит бус хурлаар хэлэлцэн хүсэлтийг хүлээн авч түүнийг мөн өдрөөр үүрэг ажлаас нь чөлөөлсөн болно. Энэ талаар Санхүүгийн зохицуулах хороо болон Хөрөнгийн биржид ажлын 1 өдрийн дотор, МонголБанкинд ажлын 3 өдрийн дотор буюу хууль, журамд заасан хугацаанд мэдэгдсэн. Хараат бус гишүүний сонгон шалгаруулалтыг 2023 оны 6 дугаар сарын 22-ны өдөр олон нийтэд өөрийн болон өндөр хандалттай мэдээллийн вебсайтууд, өдөр тутмын сонинд зарлаж, ТУЗ-ийн Засаглал, Нэр Дэвшүүлэх, Цалин Урамшууллын хорооноос зохион байгуулан ажиллаж байна. Тус мэдээллийг Зууны мэдээ, Өдрийн сонин, Өнөөдөр сонин болон www.ikon.mn, www.gogo.mn, www.xacbank сайтаар дамжуулан олон нийтэд зарласан болно.</p>
7.	<p>Үнэт цаас гаргагчийн засаглалтай холбоотой тайлан, мэдээлэл</p>
	<p>ХасБанк олон нийтэд хувьцаагаа гаргаж үнэт цаас гаргагчийн хувиар нэмэлт үүргүүд хүлээх болсонтой холбогдуулан Компанийн тухай хуульд заасан хувьцаат компанийн тусгай зохицуулалтууд, Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 145 дугаар тогтоолоор батлагдсан Компанийн засаглалын кодексийн шаардлагад нийцүүлэн нийт 16 журам шинээр болон шинэчлэн найруулсан байдлаар боловсруулж, Компанийн засаглалын кодексийн зарим шаардлагыг хангах 2023-2026 төлөвлөгөөний хамт ТУЗ-ийн 7 дугаар сарын 7-ний ээлжит хурлаар батлуулсан байна.</p>
<p>Мэдээлэл гаргагч этгээд болон мэдээллийн үнэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг, огноо:</p>	
<p>Овог, нэр: Г.Цэвэгжав</p> <p>Албан тушаал: Гүйцэтгэх захирал</p> <p>Гарын үсэг:</p> <p>(Тамга/тэмдэг)</p> 	
<p>Мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо:</p>	
<p>Овог, нэр: Г.Эрдэнэбаяр</p> <p>Албан тушаал: Санхүү хариуцсан захирал</p> <p>Гарын үсэг:</p> 	

	Балансын зүйл	Эхний үлдэгдэл /2022.12.31/	Эцсийн үлдэгдэл /2023.06.30/
1	ХӨРӨНГӨ		
1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	1,277,711,125,330.34	1,180,741,459,444.50
1.1.1	Бэлэн мөнгө	100,774,591,743.98	41,091,490,571.28
1.1.2	Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан мөнгө (3 хүртэлх сарын хугацаатай)	612,027,384,270.16	380,153,104,798.10
1.1.3	Мөнгөтэй адилтгах хөрөнгө	564,137,017,190.58	758,263,171,150.25
1.1.4	Мөнгөн хөрөнгөнд хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	772,132,125.63	1,233,692,924.87
1.2	Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө	255,682,836,623.36	229,542,938,577.17
1.2.1	Монголбанкинд байршуулсан хөрөнгө	256,086,933,009.69	229,905,721,911.45
1.2.2	Бусад банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө	-	-
1.2.3	Бусад хөрөнгө	-	-
1.2.4	Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгөнд хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	-	-
1.2.5	Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгийн эрсдэлийн сан	(404,096,386.33)	(362,783,334.28)
1.3	Хөрөнгө оруулалт	120,830,123,902.62	104,827,575,497.80
1.3.1	Арилжааны үнэт цаас	-	-
1.3.2	Борлуулахад бэлэн үнэт цаас	91,044,888,945.30	98,368,403,649.70
1.3.3	Хугацааны эцэс хүртэл эзэмших үнэт цаас	12,000,000,000.00	-
1.3.4	Зээл ба авлага гэж ангилсан бусад үнэт цаас	-	-
1.3.5	Хараат, хамтын хяналттай, охин компанид оруулсан хөрөнгө оруулалт	-	-
1.3.6	Барьцаанд байгаа үнэт цаас	12,279,000,000.00	-
1.3.7	Үнэт цаасанд хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	8,519,337,947.60	9,174,131,511.20
1.3.8	Үнэт цаасны эрсдэлийн сан	(3,013,102,990.28)	(2,714,959,663.10)
1.4	Зээл (цэвэр дүнгээр)	2,002,817,445,688.36	2,497,857,871,705.17
1.4.1	Хэвийн зээл	1,911,717,012,107.82	2,409,101,187,779.50
1.4.2	Хугацаа хэтэрсэн зээл	60,727,231,904.68	60,673,433,739.15
1.4.3	Хэвийн бус зээл	10,153,790,906.68	10,343,420,111.11
1.4.4	Эргэлзээтэй зээл	21,575,232,546.46	17,431,777,044.68
1.4.5	Муу зээл	49,878,158,874.41	47,048,081,774.68
1.4.6	Зээлийн хойшлогдсон төлбөр	(8,271,205,308.33)	(11,800,868,239.57)
1.4.7	Зээлд хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	31,570,832,312.50	38,005,159,406.56
1.4.8	Зээлийн эрсдэлийн сан	(74,533,607,655.86)	(72,944,319,910.95)
1.5	Дериватив санхүүгийн хөрөнгө	107,798,729,692.39	71,216,601,079.20
1.6	Бусад санхүүгийн хөрөнгө	14,286,075,670.40	11,319,276,884.75
1.6.1	Бусдаас авах авлага (цэвэр дүнгээр)	14,286,075,670.40	11,319,276,884.75
1.6.2	Банк, салбар хоорондын тооцоо	-	-
1.6.3	Өмчлөх бусад хөрөнгө (цэвэр дүнгээр)	-	-
1.6.4	Бусад	-	-
1.7	Бусад санхүүгийн бус хөрөнгө	68,767,517,039.92	70,542,766,989.10
1.7.1	Бусад тооцоо	21,987,106,736.59	31,321,436,205.72
1.7.2	Бараа материал, үнэ бүхий зүйл	1,983,807,244.65	2,201,906,548.42
1.7.3	Үнэт металл (цэвэр дүнгээр)	94,439,362.68	250,329,981.96
1.7.4	Өмчлөх бусад хөрөнгө (цэвэр дүнгээр)	33,153,931,641.67	21,738,374,644.37
1.7.5	Татварын авлага	21,925,455.76	21,364,244.77
1.7.6	Хойшлогдсон татварын хөрөнгө	5,232,743,421.79	4,629,903,880.29
1.7.7	Бусад	6,293,563,176.78	10,379,451,483.57
1.8	Үндсэн хөрөнгө	61,927,693,943.12	64,040,182,500.43
1.9	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	-	-
1.10	Борлуулах зориулалттай хөрөнгө	2,063,167,155.40	2,027,082,699.40
1.11	Биет бус хөрөнгө	18,895,588,438.64	18,983,293,788.51
	Нийт хөрөнгийн дүн	3,930,780,303,484.54	4,251,099,049,166.03
2	ӨР ТӨЛБӨР		
2.1	Харилцах	599,905,003,467.57	562,805,853,923.13
2.1.1	Харилцах дансны нэрлэсэн үлдэгдэл	599,905,003,467.57	562,805,853,923.13
2.1.2	Харилцах дансанд хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг	-	-
2.2	Хадгаламж	1,771,382,449,842.60	1,828,033,045,227.75
2.2.1	Хугацаагүй хадгаламж	142,277,592,644.74	162,087,606,638.92
2.2.2	Хугацаатай хадгаламж	1,607,526,693,126.36	1,643,347,173,243.24
2.2.3	Бусад төрлийн хадгаламж	12,213,869,569.20	12,171,000,823.02
2.2.4	Хадгаламжинд хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг	9,364,294,502.30	10,427,264,522.57
2.3	Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр	937,549,491,990.06	1,181,388,942,607.90
2.3.1	Банк, санхүүгийн байгууллагаас байршуулсан харилцах, хадгаламж	106,383,363,477.73	103,083,972,861.92

	Балансын зүйл	Эхний үлдэгдэл /2022.12.31/	Эцсийн үлдэгдэл /2023.06.30/
2.3.2	Банк, санхүүгийн байгууллагаас авсан зээл (хугацаа хэтэрсэн зээлийн дүнг оруулсан)	830,172,876,661.84	1,075,594,966,368.72
2.3.3	Эх үүсвэрийн хойшлогдсон төлбөр	(4,979,285,699.67)	(9,499,306,955.16)
2.3.4	Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэрт хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг	5,972,537,550.16	12,209,310,332.42
2.4	Бусад эх үүсвэр	39,660,166,538.02	26,683,855,117.77
2.4.1	Банкнаас гаргасан өрийн бичиг	-	-
2.4.2	Банкнаас гаргасан үнэт цаас	-	-
2.4.3	Төслийн зээлийн санхүүжилт	15,033,764,182.22	14,562,028,412.55
2.4.4	Буцаан худалдан авах нөхцөлөөр худалдсан үнэт цаас (repo)	9,999,283,086.03	-
2.4.5	Хамтын зээлжүүлэлтийн эх үүсвэр	363,732,899.06	406,554,666.65
2.4.6	Бусад	12,764,489,484.54	11,395,718,196.94
2.4.7	Бусад эх үүсвэрийн хойшлогдсон төлбөр	-	-
2.4.8	Бусад эх үүсвэрт хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг	1,498,896,886.16	319,553,841.63
2.5	Дериватив санхүүгийн өр төлбөр	1,639,595,288.69	4,449,050,000.00
2.6	Бусад санхүүгийн өр төлбөр	50,434,909,536.04	56,815,307,811.20
2.7	Бусад санхүүгийн бус өр төлбөр	54,521,027,007.90	49,425,455,324.31
2.8	Хоёрдогч өглөг	-	-
2.9	Давуу эрхийн хувьцаа (өр төлбөр)	-	-
	Нийт өр төлбөрийн дүн	3,455,092,643,670.88	3,709,601,510,012.07
3	ӨӨРИЙН ХӨРӨНГӨ		
3.1	Хувь нийлүүлсэн хөрөнгө	100,000,000,000.00	105,270,000,000.00
3.1.1	Давуу эрхийн хувьцаа	-	-
3.1.2	Энгийн хувьцаа	100,000,000,000.00	105,270,000,000.00
3.2	Нэмж төлөгдсөн капитал	1,817,773,344.70	30,586,768,164.70
3.3	Халаасны хувьцаа	-	-
3.4	Дахин үнэлгээний нэмэгдэл	18,528,613,201.77	18,528,613,201.77
3.5	Хуримтлагдсан ашиг, алдагдал	278,161,784,485.17	325,513,921,070.70
3.6	Бусад өөрийн хөрөнгө	77,179,488,781.95	61,598,236,716.79
3.6.1	Хувьцааны опцион	-	-
3.6.2	Нөөцийн сан	11,439,407,367.49	11,439,407,367.49
3.6.3	Ханш, үнэлгээний тэгшитгэлийн сан	-	-
3.6.4	Эрсдэлийн сангийн нөөц	62,820,178,115.26	47,660,340,021.80
3.6.5	Нийгмийн хөгжлийн сан	-	-
3.6.6	Хөрвөх өр төлбөр	-	-
3.6.7	Хувьцааны баталгаа бүхий зээл	-	-
3.6.8	Бусад	2,919,903,299.20	2,498,489,327.50
3.7	Өөрийн хөрөнгийн дүн	475,687,659,813.59	541,497,539,153.95
	Өр төлбөр ба өөрийн хөрөнгийн дүн	3,930,780,303,484.47	4,251,099,049,166.03

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

САНХҮҮ ХАРИУЦСАН ЗАХИРАЛ



Г.ЦЭВЭГЖАВ

Г.ЭРДЭНЭБЯАР


2023 оны Зургаадугаар сар 30

(Төгрөгөөр)

Д/д	Орлого, зардлын зүйл	Өмнөх үеийн /2022.12.31/	Тайлант үеийн /2023.06.30/
1	Хүүгийн орлого	375,306,477,653.35	240,360,178,377.07
1.1	Монголбанкинд байршуулсан хөрөнгийн	7,359,332,809.35	8,693,965,113.98
1.2	Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгийн	1,031,482,540.80	717,107,381.50
1.3	Үнэт цаасны	66,667,587,500.93	51,035,986,119.02
1.4	Зээлийн	290,232,727,007.36	172,465,238,873.57
1.5	Бусад хүүгийн орлого	10,015,347,794.91	7,447,880,889.01
2	Хүүгийн зардал	160,682,894,200.64	132,715,267,460.12
2.1	Харилцахад төлсөн хүү	-	529,162,639.85
2.2	Хадгаламжинд төлсөн хүү	111,705,166,881.99	74,206,732,970.91
2.3	Зээлийн хүүгийн зардал	37,775,226,655.18	42,145,074,381.10
2.4	Үнэт цаасны хүүгийн зардал	332,121,096.36	282,457,249.29
2.5	Бусад хүүгийн зардал	10,870,379,567.11	15,551,840,218.97
3	Хүүгийн цэвэр орлого [(1)-(2)]	214,623,583,452.72	107,644,910,916.95
4	Эрдэлийн сангийн зардал	10,326,230,541.11	131,476,071.90
4.1	Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгийн	485,285,379.61	117,585,466.63
4.2	Үнэт цаасны	1,451,972,562.09	13,890,605.27
4.3	Зээлийн	8,388,972,599.41	-
5	Эрдэлийн сангийн дараах цэвэр орлого [(3)-(4)]	204,297,352,911.60	107,513,434,845.05
6	Бусад орлого	59,689,634,346.60	32,329,577,216.72
6.1	Хүүгийн бус орлого	55,252,049,444.71	29,923,438,685.76
6.1.1	Арилжааны орлого	15,112,730,232.03	4,943,589,447.30
6.1.2	Ханш, үнэлгээний тэгшитгэлийн орлого	152,817,339.66	657,606,559.74
6.1.3	Банкны бүтээгдэхүүнтэй холбоотой үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого	38,725,827,574.41	22,521,668,222.22
6.1.4	Бусад хүүгийн бус орлого	1,260,674,298.61	1,800,574,456.50
6.2	Бусад орлого, олз	4,437,584,901.89	2,406,138,530.96
7	Бусад зардал	117,297,712,285.54	56,246,521,104.02
7.1	Хүүгийн бус зардал	114,919,912,998.58	55,173,755,678.33
7.1.1	Бусад эрдэлийн сангийн зардал	305,921,866.23	39,549,878.50
7.1.2	Арилжааны зардал	-	-
7.1.3	Ханш, үнэлгээний тэгшитгэлийн зардал	-	-
7.1.4	Хураамж, шимтгэлийн зардал	11,572,938,661.41	6,312,317,267.52
7.1.5	Үйл ажиллагааны бусад зардал	103,041,052,470.94	48,821,888,532.31
7.2	Бусад зардал, гарз	2,377,799,286.96	1,072,765,425.69
8	Татварын өмнөх ашиг, алдагдал (5+6-7)	146,689,274,972.67	83,596,490,957.75
9	Орлогын татварын зардал	40,850,688,811.59	21,404,192,465.66
10	Татварын дараах ашиг, алдагдал (8-9)	105,838,586,161.08	62,192,298,492.09
11	Зогсоосон үйл ажиллагааны цэвэр орлого, зардал	-	-
12	Тайлант үеийн цэвэр ашиг, алдагдал (10+11)	105,838,586,161.08	62,192,298,492.09
13	Бусад дэлгэрэнгүй орлого	854,230,310.01	(421,413,971.70)
13.1	Үндсэн хөрөнгө ба биет бус хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл дансны өсөлт, бууралт	-	-
13.2	Борлуулахад бэлэн үнэт цаасны дахин үнэлгээний өсөлт, бууралт	854,230,310.01	(421,413,971.70)
13.3	Ханш, үнэлгээний тэгшитгэлийн сангийн өсөлт, бууралт	-	-
13.4	Эрдэлийн сангийн нөөцийн өсөлт, бууралт	-	-
13.5	Бусад	-	-
14	Тайлант хугацааны нийт дэлгэрэнгүй орлогын дүн (10+11)	106,692,816,471.09	61,770,884,520.38

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

САНХҮҮ ХАРИУЦСАН ЗАХИРАЛ



Г.ЦЭВЭГЖАВ

Г.ЭРДЭНЭБАЯР

2023 оны Зургадугаар сар 30

(Төгрөгөөр)

Өөрийн хөрөнгийн зүйл	Хувь нийлүүлсэн хөрөнгө	Нэмж төлөгдсөн капитал	Хадгасны хувьцаа	Дахин үнэлгээний нэмэгдэл	Бусад өөрийн хөрөнгө	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2021 оны 12-р сарын 31-ний өдрийн үлдэгдэл Нагтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	100,000,000,000.00	1,817,773,344.70	-	18,528,613,201.77	66,073,799,064.11	197,574,657,731.92	383,994,843,342.50
Залруулсан үлдэгдэл	100,000,000,000.00	1,817,773,344.70	-	18,528,613,201.77	66,073,799,064.11	197,574,657,731.92	383,994,843,342.50
Тайлант үеийн цэвэр ашиг, алдагдал	-	-	-	-	854,230,310.01	105,838,586,161.08	105,838,586,161.08
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	10,251,459,407.83	(10,251,459,407.83)	854,230,310.01
Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-	-	(15,000,000,000.00)	(15,000,000,000.00)
Хуваарилсан ногдол ашиг	-	-	-	-	-	-	-
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-	-	-	-
2022 оны 12-р сарын 31-ний өдрийн үлдэгдэл Нагтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	100,000,000,000.00	1,817,773,344.70	-	18,528,613,201.77	77,179,488,781.95	278,161,784,485.17	475,687,659,813.59
Залруулсан үлдэгдэл	100,000,000,000.00	1,817,773,344.70	-	18,528,613,201.77	77,179,488,781.95	278,161,784,485.17	475,687,659,813.59
Тайлант үеийн цэвэр ашиг, алдагдал	-	-	-	-	(421,413,971.70)	62,192,298,492.09	62,192,298,492.09
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	(15,159,838,093.46)	15,159,838,093.46	(421,413,971.70)
Өмчид гарсан өөрчлөлт	5,270,000,000.00	28,768,994,820.00	-	-	-	(30,000,000,000.00)	34,038,994,820.00
Хуваарилсан ногдол ашиг	-	-	-	-	-	-	(30,000,000,000.00)
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-	-	-	-
2023 оны 6-р сарын 30-ны өдрийн үлдэгдэл	105,270,000,000.00	30,586,768,164.70	-	18,528,613,201.77	61,598,236,716.79	325,513,921,070.72	541,497,539,153.97

ГҮЙЦЭГТЭХ ЗАХИРАЛ

Г.ЦЭВЭГЖАВ

САНХҮҮ ХАРИУЦСАН ЗАХИРАЛ

Г.ЭРДЭНЭБДЯР



	Үзүүлэлт	Өмнөх үеийн /2022.12.31/	Тайланг үеийн /2023.06.30/
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ:	***	***
1.1	Орлогын татварын өмнөх ашиг (алдагдал)	148,071,320,949.90	82,853,180,092.35
1.2	Орлого, зардлын төхируулга:	(196,931,218,438.58)	(105,511,554,696.88)
1.2.1	Эрдэлийн сангийн зардал (+)	9,246,082,215.64	(1,988,274,935.41)
1.2.2	Элэгдэл, хорогдлын зардал (+)	8,237,113,823.79	4,892,453,591.46
1.2.3	Ханш, үнэлгээний тэгшитгэлийн орлого (-), зардал (+) (Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгөөс бусад)	-	-
1.2.4	Хуримтлуулсан хүүгийн орлого (-)	(375,306,477,653.35)	(240,360,178,377.07)
1.2.5	Хуримтлуулсан хүүгийн зардал (+)	160,682,894,200.64	132,715,267,460.12
1.2.6	Хөрөнгө данснаас хассаны олз (-), гарз (+)	315,321,867.10	(770,822,435.98)
1.2.7	Бусад олз (-), гарз (+)	(106,152,892.40)	-
1.3	Хөрөнгө, өр төлбөрийн өөрчлөлтийн төхируулга:	(20,598,882,369.48)	(408,039,986,784.83)
1.3.1	Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгийн өсөлт (-), бууралт (+)	(41,677,850,565.31)	26,181,211,098.24
1.3.2	Арилжааны үнэт цаасны өсөлт (-), бууралт (+)	-	-
1.3.3	Зээлийн өсөлт (-), бууралт (+)	(202,713,557,293.35)	(487,016,811,177.84)
1.3.4	Бусад санхүүгийн хөрөнгийн өсөлт (-), бууралт (+)	(67,705,034,405.49)	39,509,377,520.35
1.3.5	Бусад санхүүгийн бус хөрөнгийн өсөлт (-), бууралт (+)	(1,622,485,554.42)	(2,316,931,106.80)
1.3.6	Харилцах, халгаламжийн өсөлт (+), бууралт (-)	166,437,551,573.69	18,488,475,820.43
1.3.7	Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэрийн өсөлт (+), бууралт (-)	122,624,379,285.23	(15,187,405,971.98)
1.3.8	Бусад санхүүгийн өр төлбөрийн өсөлт (+), бууралт (-)	4,659,813,539.33	9,189,852,986.48
1.3.9	Бусад санхүүгийн бус өр төлбөрийн өсөлт (+), бууралт (-)	(601,698,949.16)	3,112,244,046.29
1.4	Бусад төхируулга:	171,665,781,840.01	78,515,754,996.52
1.4.1	Авсан хүү (+)	358,360,333,497.43	233,271,057,719.40
1.4.2	Төлсөн хүү (-)	(156,546,990,324.76)	(126,594,867,702.12)
1.4.3	Орлогын татварын төлөлт (-)	(23,098,641,251.06)	(28,160,435,020.76)
1.4.4	Эрдэлийн сангаас хаасан зээл, авлага (-)	(7,048,920,081.61)	-
1.4.5			
1.5	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	102,207,001,981.85	(352,182,606,392.84)
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ:	***	***
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	22,800,871,676.40	25,186,236,391.81
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	40,451,771.75	3,535,000.00
2.1.2	Биет бус хөрөнгө борлуулсны орлого	-	-
2.1.3	Хөрөнгө оруулалтын зориулалттай хөрөнгө борлуулсны орлого		
2.1.4	Охин компани, хараат компани, хамтын хяналттай аж ахуйн нэгжид оруулсан хөрөнгө оруулалт борлуулсны орлого		
2.1.5	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого	878,485,516.18	903,701,391.81
2.1.6	Зээл ба авлага гэж ангилан хорогдуулсан өртгөөр бүртгэсэн хөрөнгө оруулалт		
2.1.7	Борлуулахад бэлэн үнэт цаас борлуулсны орлого	176,034,388.47	-
2.1.8	Хугацааны эцэс хүртэл эзэмших үнэт цаас борлуулсны орлого	-	12,000,000,000.00
2.1.9	Хүлээн авсан ногдол ашиг		
2.1.10	Бусад мөнгөн орлого	21,705,900,000.00	12,279,000,000.00
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	(19,599,178,724.63)	(15,005,406,136.66)
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	8,197,713,700.37	5,482,839,760.43
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	5,509,236,391.88	1,509,451,948.27
2.2.3	Хөрөнгө оруулалтын зориулалттай хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
2.2.4	Охин компани, хараат компани, хамтын хяналттай аж ахуйн нэгжид оруулсан хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн		
2.2.5	Зээл ба авлага гэж ангилан хорогдуулсан өртгөөр бүртгэсэн хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн		
2.2.6	Борлуулахад бэлэн үнэт цаас олж эзэмшихэд төлсөн	3,900,900,000.03	7,815,518,503.93
2.2.7	Хугацааны эцэс хүртэл эзэмших үнэт цаас олж эзэмшихэд төлсөн	-	-
2.2.8	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	1,991,328,632.35	197,595,924.03
2.2.9	Бусад мөнгөн зарлага	-	-
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	3,201,692,951.77	10,180,830,255.15
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ:	***	***
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	368,524,930,695.15	503,349,894,820.00
3.1.1	Бусад эх үүсвэр татаж хүлээн авсан	368,524,930,695.15	469,310,900,000.00
3.1.2	Хоёрдогч өглөгөөс хүлээн авсан	-	-
3.1.3	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		34,038,994,820.00
3.1.4	Төрөл бүрийн хандив		
3.1.5	Бусад		
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	(359,835,821,693.02)	(258,317,784,568.15)
3.2.1	Бусад эх үүсвэрт төлсөн	344,835,821,693.02	228,317,784,568.15
3.2.2	Хоёрдогч өглөгт төлсөн		
3.2.3	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		
3.2.4	Хувьцаа буцаан худалдан авахад төлсөн		
3.2.5	Төлсөн ногдол ашиг	15,000,000,000.00	30,000,000,000.00
3.2.6	Бусад		
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	8,689,109,002.13	245,032,110,251.85
4	Валютын ханшийн зөрүү		
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	114,097,803,935.76	(96,969,665,885.84)
6	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,163,613,321,394.59	1,277,711,125,330.34
7	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,277,711,125,330.34	1,180,741,459,444.50

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

САНХҮҮ ХАРИУЦСАН ЗАХИРАЛ



Г.ЦЭВЭГЖАВ

Г.ЭРДЭНЭБАЯР

**“ХАСБАНК”-НЫ ТАТАН ТӨВЛӨРҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН
ЗАРЦУУЛАЛТЫН ТАЙЛАН**
(2023 оны 6-р сарын 30-ний байдлаар)



1. Татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын төлөвлөгөө

ХасБанк нь үнэт цаасны танилцуулгад тусгасны дагуу олон нийтэд шинээр санал болгож буй 52,700,000 ширхэг энгийн хувьцааг амжилттай арилжаалж, 35,667,900,000 төгрөгийн санхүүжилтийг татан төвлөрүүлсэн болно. Энэхүү санхүүжилтээс шинээр үнэт цаас гаргахтай холбогдон гарсан 1,628,905,180 төгрөгийг шууд зардлуудыг холбогдох журам, СТОУС-ийн дагуу хасаж, үлдсэн хөрөнгийг Банкны зээл, санхүүгийн түрээсийн багцыг санхүүжүүлэхээр төлөвлөсөн. Үнэт цаас гаргахтай холбоотой шууд зардалд:

- Райнос Инвестмент ҮЦК ХХК болон Өлзий энд Ко Капитал ҮЦК ХХК-д төлөх андеррайтерийн шимтгэл;
- Үнэт цаасны бүртгэлийн журмын 2.1-р заалтын дагуу БДО Аудит ХХК-р гүйцэтгүүлсэн бизнесийн үнэлгээний төлбөр;
- Үнэт цаасны бүртгэлийн журмын 3.1.4-р заалтын дагуу Эрнст энд Янг Монголия Аудит ХХК-р гүйцэтгүүлсэн аудиторын тодорхойлох захидал, дүгнэлтийн төлбөр;
- Үнэт цаасны бүртгэлийн журмын 2.1 заалтын дагуу Өмгөөллийн “Батбаяр энд Партнерс” ХХН-өөр гүйцэтгүүлсэн хуулийн дүгнэлтийн төлбөр;
- МХБ-ийн бүртгэлийн болон анхдагч зэх зээлийн хураамж;
- ҮЦТХТ-ийн бүртгэлийн болон анхдагч зах зээлийн хураамж;
- Бусад зохицуулагч байгууллагуудын шимтгэл.

Үнэт цаас гаргахтай холбоотой дээр дурдсан шууд зардлыг хассаны дараах цэвэр татан төвлөрүүлсэн хөрөнгийн дүн 34,038,994,820 төгрөг болно.

2. Цэвэр санхүүжилтийн зарцуулалтын хэрэгжилт

Зээлийн сегмент	Цэвэр санхүүжилтийг зарцуулах хувь	Цэвэр санхүүжилтийг зарцуулах дүн	2023 оны 6 сарын 30-ний байдлаарх зарцуулалт*
Иргэдийн зээлийн багц	66%	22,465,736,581	17,836,323,782
Байгууллагын зээлийн багц	19%	6,467,409,016	410,959
Санхүүгийн түрээсийн багц	15%	5,105,849,223	2,738,483,452
Нийт	100%	34,038,994,820	20,575,218,193

* Зээл, санхүүгийн түрээсийн үлдэгдэл дүнгээр

Цэвэр санхүүжилтээс зарцуулаагүй үлдэгдэл 13,463,776,627 төгрөг байна.



ХАСБАНКНЫ 2023 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН

САНХҮҮ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ

ТАЙЛАН

2023 оны эхний хагас жилийн ҮР ДҮН

Цэвэр ашиг

62.2 тэрбум ₮

▲ 27.0% YOY

Нийт актив

4,251.1 тэрбум ₮

▲ 8.1% YTD

Чанаргүй зээл***

2.9%

Гадаад эх үүсвэр

288.0 сая \$

▲ 37.7% YTD

EPS*

59.1 төгрөг

ROE**

26.1%

Харилцах, хадгаламж

2,421.8 тэрбум ₮

▲ 0.2% YTD

Зээл, санхүүгийн түрээсийн багц

2,544.6 тэрбум ₮

▲ 23.9% YTD

Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн
хөрөнгийн хүрэлцээ
19.1%
Төлбөр түргэн гүйцэтгэх
чадварын харьцаа
36.6%

YOY Тайлант хугацааны үзүүлэлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулсан өөрчлөлт

YTD Тайлант хугацааны эцсийн үзүүлэлтийг жилийн эхний үзүүлэлттэй харьцуулсан өөрчлөлт

* Earnings per share – тайлант хугацааны цэвэр ашгийг гаргасан хувьцааны тоонд харьцуулан тооцсон

** Тайлант хугацааны цэвэр ашгийг оны эхний өөрийн хөрөнгийн үлдэгдэлд харьцуулан тооцож, жилрүү хөрвүүлсэн

*** Монголбанкны холбогдох журмын дагуу чанаргүйд ангилсан зээлийн багцыг нийт зээлийн багцад харьцуулан тооцсон

1

Онцлох үйл явдал

2

Санхүүгийн үзүүлэлт

3

Зохистой харьцааны шалгуур үзүүлэлт

4

Үйл ажиллагаа

5

Засаглал

Онцлох үйл явдал



Нээлттэй хувьцаат компани боллоо

ХасБанк нийт хувьцааныхаа 5.01% буюу 35.7 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлэхээр 52.7 сая ширхэг хувьцааг олон нийтэд санал болгосноос анхдагч зах зээл дээр 9,944 хөрөнгө оруулагчийн 41.8 тэрбум төгрөгийн захиалга ирж, арилжаа 117.2%-ийн биелэлттэй хаагдлаа.




105 сая ам.долларын эх үүсвэр татлаа

Бичил, жижиг дунд бизнес эрхлэгч эмэгтэйчүүд болон ногоон бизнесийг дэмжихээр Олон Улсын Санхүүгийн Корпораци, Нидерландын Хөгжлийн Агентлагаас нийт **105 сая ам.долларын** эх үүсвэр татлаа.



УАНС-аас 2 дахь удаагаа магадлан итгэмжлэгдлээ


НҮБ-ын Уур амьсгалын ногоон сантай "Магадлан итгэмжлэлийн мастер гэрээ" байгууллаа.



ТОП-100 ААН-ийн нэгээр шалгарлаа

Монгол Улсын Засгийн газар, МҮХАҮТ-аас зарладаг ТОП-100 ААН-ийн нэгээр дахин шалгарлаа.

Онцлох үйл явдал



Цалингийн хадгаламж

Илүү өгөөжтэй, Илүү боломжтой, Илүү урт хугацаанд тогтвортой өсөх Цалингийн хадгаламжийн бүтээгдэхүүнийг зах зээлд гаргалаа.



Онлайн цалингийн зээл

Цалингийн зээлийг дижитал банкаар авдаг боллоо. ХасБанкаар цалингаа авдаг байх шаардлагагүй бөгөөд НДШ төлдөг л бол цалингийн зээл авах боломжтой.

Зээл олголт: **58.8** тэрбум ₮



Ипотекийн 3%-ийн зээл

Монголбанктай хамтран Орон нутгийн иргэдэд орон сууцны 3%-ийн зээлийг олгож эхэллээ.



Хүнс, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих зээл

Хүнс, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих хөнгөлөлттэй зээлийн хүсэлтийг орон даяарх бүх салбараараа хүлээн авч шийдвэрлэлээ.

Зээл олголт: **73.7** тэрбум ₮



Картын буцаан олголт

Карт эзэмшигч нартаа зориулан ХасБанкны мерчант дээр худалдан авалт тутамдаа буцаан олголт авах аяныг тогтмол хэрэгжүүллээ.



Эмэгтэй бизнес эрхлэгчдийг дэмжих зээл

Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдэд 50 сая төгрөг хүртэлх зээл барьцаагүй, хүүгийн хөнгөлөлттэй зээлийг ажлын 8 цагт шийдэж байна.

Зээл олголт: **202** тэрбум ₮

Дижитал хэрэглэгч
▲ **27.1%**

POS терминал
▲ **28.0%**

Нийт гүйлгээ
▲ **17.0%**

Онцлох үйл явдал



Лизингийн газрын багц

Лизингийн газрын багцын хэмжээ 313.3 тэрбум төгрөг болж оны эхнээс 41%-р өслөө. Үүнд шинэ суудлын автомашины лизингийн багцын өсөлт голлон нөлөөллөө.



Автомашини зээлийн төв

2023/05 сард "Гаальтай автомашин"-ы зээлийн үйлчилгээгээр дагнасан Автомашини зээлийн төвүүдийг "Да хүрээ худалдааны төв" болон "22 авто худалдааны төв"-д тус тус нээлээ. Тус зээлийн төвүүд нь зээлийн шийдвэрийг 2 цагт багтаан шийдвэрлэж байна.



Эко Лизинг

Байгаль орчинд ээлтэй цахилгаан машиныг хөнгөлөлттэй нөхцөлтэй лизингээр санхүүжүүлж байна. 7.0 тэрбум төгрөгийн үнэ бүхий цахилгаан автомашиныг санхүүжүүлээд байна.



МАДА – Улаанбаатар автошоу 2023

МАДА – Улаанбаатар автошоу 2023 Авто экспо-д "Санхүүгийн түнш байгууллага"-аар оролцлоо. Авто экспо-д 17 брэндийн шинэ загварууд танилцуулагдсан ба нийт 10,000 гаруй зочид ирж сонирхжээ.



ХасМоргейж – Хаус зээл

ХасМоргейж нь "1 ӨДӨРТ" шийдвэрлэдэг Хаус худалдан авах зээлийн үйлчилгээг нэвтрүүллээ. Хаус-с гадна 80м2 дээш талбайтай орон сууц худалдан авах зээлийг мөн адил 1 өдөрт багтаан шийдвэрлэж байна.



Хамтын ажиллагаа – Century 21

Олон улсын нэр хүндтэй үл хөдлөх хөрөнгө зуучлалын Century 21 Mongolia-тай хамтын ажиллагааг эхлүүллээ. Энэ хүрээнд Century 21 Mongolia бүсийн бүх салбар оффисын агентуудаар үйлчлүүлж буй харилцагч нар амины орон сууц болон 80мкв-с дээш талбай бүхий өндөр зэрэглэлийн орон сууцны зээлийн хүсэлтийг 1 ӨДӨРТ шийдвэрлэнэ.

1

Онцлох үйл явдал

2

Санхүүгийн үзүүлэлт

3

Зохистой харьцааны шалгуур үзүүлэлт

4

Үйл ажиллагаа

5


Засаглал

Ашигт ажиллагаа

ХасБанк нь сүүлийн жилүүдэд авч хэрэгжүүлж буй бодлогын арга хэмжээнүүдийн үр дүнд Банкны балансын бүтэц болон ашигт ажиллагааг сайжруулан ажиллаж байна. Сүүлийн 5-6 улиралд дараалан өсөж байгаа төгрөгийн болон ам.долларын бодлогын хүү нь санхүүжилтийн зардлыг нэмэгдүүлж, маржинд сөрөг нөлөө үзүүлж байгаа хэдий ч, ХасБанк нь чанаргүй активыг бага дор түвшинд хадгалах замаар эрсдэлийн сангийн зардлыг бууруулж, мөн орлого олдог активт эзлэх зээлийн багцын хэмжээг нэмэгдүүлснээр 2023 оны эхний 2 улирлын цэвэр ашгийн хэмжээг 30 тэрбум төгрөгөөс дээш давуулан ажиллаж байна.

Цэвэр ашиг (тухайн улирлын)


Тэрбум төгрөгөөр



Өөрийн хөрөнгийн өгөөж (ROE)

Тухайн оны цэвэр ашиг өссөн дүнгээр

Цэвэр ашиг/жилийн эхний өөрийн хөрөнгө*



Цэвэр ашиг/жилийн дундаж өөрийн хөрөнгө

Mar 2022 Jun 2022 Sep 2022 Dec 2022 Mar 2023 Jun 2023

*БДО Аудит ХХК-ийн аргачлалын дагуу жилийн эхний өөрийн хөрөнгийн үлдэгдэлд цэвэр ашгийг харьцуулан тооцсон.

АКТИВ



ХасБанк нь сүүлийн жилүүдэд авч хэрэгжүүлж буй бодлогын арга хэмжээнүүдийн үр дүнд Банкны балансын бүтэц болон ашигт ажиллагааг сайжруулан ажиллаж байна. Сүүлийн 5-6 улиралд дараалан өсөж байгаа төгрөгийн болон ам.долларын бодлогын хүү нь санхүүжилтийн зардлыг нэмэгдүүлж, маржинд сөрөг нөлөө үзүүлж байгаа хэдий ч, ХасБанк нь чанаргүй активыг бага дор түвшинд хадгалах замаар эрсдэлийн сангийн зардлыг бууруулж, мөн орлого олдог активт эзлэх зээлийн багцын хэмжээг нэмэгдүүлснээр балансын үр ашиг нэмэгдсэн болно.


Нийт актив

Тэрбум төгрөгөөр



Активын өгөөж (aROA)

Тухайн оны цэвэр ашиг өссөн дүнгээр



*Тухайн онд ирээдүйд учирч болзошгүй эрсдэлийг бууруулах зорилгоор анхаарал татсан зээлүүдийг төлүүлж, мөн МБ-ны зохицуулалт өөрчлөгдсөнтэй холбоотой (өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлт чангарсан) эрсдэлээр жигнэсэн активыг бууруулах стратеги баримтлан ажилласан.

Зээл, санхүүгийн түрээсийн багц

Зээлийн үйл ажиллагаа нь Иргэдийн банк, Байгууллагын банк, Хаслизинг (Санхүүгийн түрээс) гэсэн үндсэн гурван бизнесийн сегментэд хуваагддаг. 2023 оны эхний 2 улиралд Иргэдийн банкны зээлийн багц 26.0%-аар, Байгууллагын банкны зээлийн багц 8.1%, Хаслизингийн багц 40.8%-р тус тус өслөө. Иргэдийн банкны зээлийн багц өсөхөд “Таблет Банкинг” үйлчилгээ чухал үүрэг гүйцэтгэсэн бол Хаслизингийн багц нэмэгдэхэд Монгол Улсын гадаад худалдаа, түүний тээврийн асуудал хэвийн горимруу шилжиж буйтай зэрэгцээд шинэ машин, механизмын худалдаа сайжирсан нь голлон нөлөөлсөн. Тайлант хугацаанд чанаргүй зээлийг бууруулах стратегийн дагуу чанаргүй зээлийг тогтмол бууруулж, нийт зээлийн багцын 2.9%-д хүргэлээ.


Зээл ба санхүүгийн түрээс

Тэрбум төгрөгөөр



Зээлийн багц бизнесийн сегментээр

Тэрбум төгрөгөөр



*Тухайн онд ирээдүйд учирч болзошгүй эрсдэлийг бууруулах зорилгоор анхаарал татсан зээлүүдийг төлүүлж, мөн МБ-ны зохицуулалт өөрчлөгдсөнтэй холбоотой (өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлт чангарсан) эрсдэлээр жигнэсэн активыг бууруулах стратеги баримтлан ажилласан.

Харилцах, хадгаламж

ХасБанк нь харилцагчдадаа бизнесийн болон хувийн дансаа шуурхай, найдвартай удирдахад нь зориулан харилцах дансны үйлчилгээг санал болгодог. Харин хадгаламжийн бүтээгдэхүүн нь энгийн хугацаагүй хадгаламжаас эхлээд хүүгээ сар бүр зарлагадах боломжтой хугацаатай хадгаламж, хүүхдийн урт хугацааны хуримтлалын хөтөлбөрүүдээс бүрддэг. 2023 оны эхний 2 улирлын байдлаар хадгаламж 3.1% өссөн бол харилцах дансны үлдэгдэл 7.7%-аар буурсан байна. Харилцах дансны үлдэгдэл харилцагчийн бизнесийн онцлог, мөнгөн урсгалын мөчлөгөөс хамаарч сарын эцсийн үлдэгдэл ихээхэн хэлбэлзэлтэй байдаг.

Харилцах, хадгаламжийн үлдэгдэл


Тэрбум төгрөгөөр



* 2022 оны санхүүгийн жилийн эцсээр байгууллагын харилцагчдын дансны үлдэгдэл түр нэмэгдсэн.

Бүтээгдэхүүнээр

Тэрбум төгрөгөөр



Гадаад эх үүсвэр

ХасБанк нь харилцагчдадаа урт хугацаатай санхүүжилт олгох зорилгоор Олон Улсын санхүүгийн байгууллагуудтай хамтран ажиллаж байна. 2022 онд хэд хэдэн урт хугацаатай эх үүсвэр татах хэлцэл амжилттай хийлээ. Тухайлбал ОУСК-тай 80 сая ам.долларын синдикат эх үүсвэр, FMO-тай 50 сая ам.долларын урт хугацаатай эх үүсвэр, ЕСБХБ-тай нийт 50 сая ам.долларын урт хугацаатай 2 удаагийн хэлцэл, BlueOrchard Fund-тай 30 сая ам.долларын хэлцэл, DWM Income Fund-тай 11 сая ам.долларын хэлцэл, Incofin Mikrofinanz Fund-тай 10 сая ам.долларын хэлцэл, Symbiotics-тай 7.5 сая ам.долларын хэлцэл тус тус байгуулан эх үүсвэрийг амжилттай татаад байна.

Гадаад эх үүсвэрийн үлдэгдэл

Сая ам.доллараар



Санхүүжүүлэгч түнш байгууллагууд



* Банкны төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа үзүүлэлт 2020 онд 54.9%, 2021 онд 44.3% буюу зохистой хэмжээнээс харьцангуй өндөр байсантай уялдуулан шинээр гадаад эх үүсвэр татах хэлцэл хийгээгүй бөгөөд хуучин эх үүсвэрүүд гэрээний дагуу жил бүр төлөгдөж, нийт үлдэгдэл тус онуудад буурсан.

1

Онцлох үйл явдал

2

Санхүүгийн үзүүлэлт

3

Зохистой харьцааны шалгуур үзүүлэлт

4

Үйл ажиллагаа

5

Засаглал

Монголбанкнаас тогтоосон нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлт


Монголбанкнаас банкуудад нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн харьцаа үзүүлэлтийн доод хязгаарыг 9%-аар тогтоосон байдаг. Мөн системийн нөлөө бүхий банкуудад нөөц интервалын шаардлага нэмж тогтоодог. Монголбанкнаас ХасБанканд тогтоосон нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн хүрэлцээний доод хязгаар болон нөөц интервалын нийлбэр 12.5% байна. ХасБанк нь нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн харьцаа үзүүлэлтээ тайлант хугацаанд 19.1% буюу байвал зохих хэмжээнээс 6.6 нэгж хувиар давуулан хангаж ажиллалаа. Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн үзүүлэлтийг байвал зохих хэмжээнээс давуулан хангах нь аливаа болзошгүй эрсдэлийг хүлээх чадвар тэр хэмжээгээр нэмэгддэг болно.

Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлт



Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн хүрэлцээний нэмэлт шаардлага

Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн хүрэлцээний доод шаардлага



Давуулан биелүүлсэн нөөц өөрийн хөрөнгө нь аливаа болзошгүй эрсдэлийг даахаас гадна ирээдүйд активын тэлэлт хийх боломжийг бий болно.

*Нөөцийн интервалын шаардлагыг Монголбанк 2019 оноос эхлэн хэрэгжүүлсэн.

Монголбанкнаас тогтоосон төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа үзүүлэлт

Арилжааны банкуудад Монголбанкнаас төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа үзүүлэлтийн доод хязгаарыг 25%-аар тогтоосон байдаг. Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа үзүүлэлтийг тооцохдоо банкны балансад бүртгэлтэй “Түргэн борлогдох актив хөрөнгө”-г “Бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгө”-д харьцуулан тооцдог. ХасБанк нь 2023 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар 1,332.5 тэрбум төгрөгийн “Түргэн борлогдох актив”-тай, 3,654.6 тэрбум төгрөгийн “Бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгө”-тэй байна. ХасБанк нь өөрийн эрсдэлийн удирдлагын бодлогын хүрээнд түргэн борлогдох актив хөрөнгийг бэлэн мөнгө эсхүл хамгийн бага эрсдэлтэйд тооцогдох хэрэгсэлд байршуулан удирдаж байна.

Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа үзүүлэлт



*Тухайн онд ирээдүйд учирч болзошгүй эрсдэлийг бууруулах зорилгоор анхаарал татсан зээлүүдийг төлүүлж, мөн МБ-ны зохицуулалт өөрчлөгдсөнтэй холбоотой (өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлт чангарсан) эрсдэлээр жигнэсэн активыг бууруулах стратеги баримтлан ажиллаж, бэлэн мөнгө болон түүнтэй адилтгах түргэн борлогдох активыг нэмэгдүүлсэнтэй холбоотойгоор төлбөр түргэн гүйцэтгэх чадварын үзүүлэлт өссөн болно.

Түргэн борлогдох актив



Монголбанкнаас тогтоосон бусад зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд

Тусгайлан өөрөөр заагаагүй бол хувиар (%) илэрхийлэв	2020 оны 12-р сарын 31-ний байдлаар	2021 оны 12-р сарын 31-ний байдлаар	2022 оны 12-р сарын 31-ний байдлаар	2023 оны 3-р сарын 31	2023 оны 6-р сарын 30
Гадаад валютын нээлттэй позиц болон өөрийн хөрөнгийн харьцаа (нэгж валютаар) +/-15%	-1.8%	-1.1%	6.2%	9.4%	4.4%
Гадаад валютын нээлттэй позиц болон өөрийн хөрөнгийн харьцаа (нийт валютаар) +/-30%	-4.2%	-2.2%	6.9%	14.5%	4.7%
Нийт томоохон зээлдэгчдэд олгох активын төвлөрлийн харьцаа** <300%	77.2%	72.8%	66.6%	39.1%	37.1%
Үндсэн хөрөнгө нийт хөрөнгийн харьцаа <8%	2.5%	1.7%	1.7%	1.6%	1.6%
Хадгаламжийн төвлөрлийн харьцаа*** <25%	7.0%	7.1%	7.7%	8.8%	7.0%

Тусгайлан өөрөөр заагаагүй бол хувиар (%) илэрхийлэв	2020 оны 12-р сарын 31-ний байдлаар	2021 оны 12-р сарын 31-ний байдлаар	2022 оны 12-р сарын 31-ний байдлаар	2023 оны 3-р сарын 31	2023 оны 6-р сарын 30
Банкны холбогдох нэг этгээд (нэгдмэл сонирхолтой этгээд)-д олгосон зээл болон зээлтэй адилтган тооцох бусад актив (Өөрийн хөрөнгийн 5 хувиас хэтрэхгүй):					
Банкны нийт хувьцаа эзэмшигчид	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%
Банкны эрх бүхий албан тушаалтан	0.2%	0.1%	0.1%	0.1%	0.1%
Банкны бусад холбогдох этгээд	1.8%	1.8%	1.6%	2.4%	3.6%
Банкны нийт холбогдох этгээдүүд (нэгдмэл сонирхолтой этгээдүүд)-д олгосон зээл болон зээлтэй адилтган тооцох бусад актив (Өөрийн хөрөнгийн 20 хувиас хэтрэхгүй):					
Банкны нийт хувьцаа эзэмшигчид	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%
Банкны эрх бүхий албан тушаалтан	0.5%	0.4%	0.3%	0.3%	0.3%
Банкны бусад холбогдох этгээд	3.6%	4.5%	3.8%	3.9%	5.9%

1

Онцлох үйл явдал

2

Санхүүгийн үзүүлэлт

3

Зохистой харьцааны шалгуур үзүүлэлт




4

Үйл ажиллагаа

5

Засаглал

Харилцагчид



Нийт харилцагчдын

65%

эмэгтэй бөгөөд эмэгтэй бизнес эрхлэгчдэд зориулсан илүү таатай нөхцөлтэй бүтээгдэхүүн үйлчилгээг гаргаж дэмжин ажиллаж байна.

Монгол эх орныхоо дөрвөн зүг найман зовхист

1 сая гаруй харилцагчдаа

банкны үйлчилгээг **уламжлалт** болон **дижитал сувгаар** хүргэж байна.



1,175
ажилтан



360
ATM



72
салбар



+7,000
ПОС, Мерчант



Уур Амьсгалын Ногоон Сангийн
Үндэсний Хэрэгжүүлэгч Байгууллага

Ногоон санхүүжилт

Эрчим хүчний хэмнэлттэй, байгаль орчинд ээлтэй ногоон бизнес, эко хэрэглээг дэмжих эко хэрэглээний болон хүлэмжийн хийг бууруулах бизнесийн зээлийн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлдэг.

ХасБанк 2013 оноос хойш

2,340,220 тонн

CO₂-той тэнцэх хэмжээний хүлэмжийн хийн ялгарлыг бууруулсан.

Энэ нь

168,601,802

ширхэг шилмүүст болон навчит мод тарьж **10 жил** ургуулсантай ижил үр дүн юм.

Нэг га-д

300 мод

тарьсан гэвэл **168,601,802** ширхэг мод нь Улаанбаатар хотоос **1.2** дахин том газрыг бүрхэнэ.

2016 онд:

ХасБанк НҮБ-ын Уур Амьсгалын Ногоон Сангийн Үндэсний Хэрэгжүүлэгч Байгууллагаар магадлан итгэмжлэгдсэн **Монгол Улс** төдийгүй **дэлхийн анхны хувийн арилжааны банк** болсон.

2022 онд:

ХасБанк НҮБ-ын Уур Амьсгалын Ногоон Сангийн Үндэсний хэрэгжүүлэгч байгууллагаар хоёр дахь удаагаа магадлан итгэмжлэгдлээ.

Эхний магадлан итгэмжлэлийн 5 жилийн хугацаанд Уур Амьсгалын Ногоон Сантай хамтран нийт 9 төсөл хөтөлбөрийг хэрэгжүүллээ. Эдгээр төсөл хөтөлбөрийн хүрээнд нийт **87.4 сая ам.долларын** санхүүжилт хийснээс **32.4 сая ам.долларын** санхүүжилтийг Уур Амьсгалын Ногоон Сангаас хийлээ.

9 төсөлд

87.4 сая ам.доллар

санхүүжилт олгосноос

5 хэрэгжиж дууссан

4 хэрэгжиж буй

Хүний нөөцийн тогтвортой хөгжлийн бодлого

ХасБанк үүсгэн байгуулагдсан цагаасаа “Жендерийн тэгш байдлын бодлого”-ыг хэрэгжүүлж, байгууллагын зөв соёл, үлгэр жишээ сайн засаглалыг хөгжүүлэн бэхжүүлж, шударга тогтвортой хөдөлмөрийн харилцааг үүсгэхэд зорин ажиллаж ирсэн. Иймдээ ч Хасчууд маань банкандаа **тогтвортой** тууштай ажилладаг ба ажилласан дундаж хугацаа **7.8 жил**. Мөн банк дотроосоо дэвшүүлэх бодлогыг барин ажиллаж ирсэн бөгөөд нийт удирдлагуудын **90%** нь дотроосоо дэвшсэн байна.



Зээлжих зэрэглэл

Банк 2008 оноос дэлхийн хамгийн нэр хүндтэй үнэлгээний агентлагууд болох Moody's Investors Service болон Fitch Ratings байгууллагуудаар өөрийн зээлжих зэрэглэлийн үнэлгээг тасралтгүй хийлгэж байна.

Moody's INVESTORS SERVICE

	ХасБанк	Монгол Улс
Зээлжих зэрэглэл - Гадаад валют	B3/NP	B3/NP
Зээлжих зэрэглэл- Төгрөг	B2/NP	B3/NP
Банкны хадгаламж	B3/NP	
Суурь зээлжих зэрэглэл	B3	B3
Үнэт цаас гаргагчийн зээлжих зэрэглэл	B3	B3
Хэтийн төлөв	Stable	Stable

FitchRatings

	ХасБанк	Монгол Улс
Урт хугацааны гадаад валютын зээлжих зэрэглэл	B/тогтвортой	B/тогтвортой
Богино хугацааны гадаад валютын зээлжих зэрэглэл	B	B
Урт хугацааны төгрөгийн зээлжих зэрэглэл	B/тогтвортой	B/тогтвортой



1

Онцлох үйл явдал

2

Санхүүгийн үзүүлэлт

3

Зохистой харьцааны шалгуур үзүүлэлт

4


Үйл ажиллагаа

5

Засаглал

ХасБанкны хувьцаа эзэмшлийн бүтэц

2023 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар




* Нээлттэй хувьцаат компани болсны дараа Тэнгэр Санхүүгийн Нэгдэл бүтцийн өөрчлөлт хийж, одоогийн хувьцаа эзэмшигчид ХасБанкны шууд хувьцаа эзэмшигч болох үйл ажиллагаа хийгдэж байгаа. Энэхүү ажил нь хуулийн дагуу 2023.12.31-ний өдрөөс өмнө бүрэн хийгдэж дуусахаар байна.

** “Нээлттэй нийгэм форум” ТББ болон “Улаанбаатар Ротари Клуб” ТББ тус бүрийн эзэмшиж буй хувьцааг Тэнгэр Санхүүгийн Нэгдэл ХХК-д эргүүлэн худалдан авч, тэдгээрийн хувь эзэмшлийг хүчингүй болгож буйтай холбогдуулан Монголбанкнаас холбогдох зөвшөөрлийг авсан бөгөөд тус үйл ажиллагааг ойрын хугацаанд хэрэгжүүлэх төлөвлөгөөтэй байна.

Хөрөнгө оруулагчид

Үндэсний хэмжээний корпораци, Олон улсын томоохон банк, санхүүгийн байгууллага болон компаниуд

Нэг хувьцаа эзэмшигч **20%**-аас илүүгүй хувь эзэмших тухай хуулийн шаардлагыг одоогоор эцсийн өмчлөгчийн хувьд хангаж буй системийн хэмжээний цорын ганц банк.



* "Нээлттэй нийгэм форум" ТББ болон "Улаанбаатар Ротари Клуб" ТББ тус бүрийн эзэмшиж буй хувьцааг ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК-д эргүүлэн худалдан авч, тэдгээрийн хувь эзэмшлийг хүчингүй болгож буйтай холбогдуулан Монголбанкнаас холбогдох зөвшөөрлийг авсан бөгөөд тус үйл ажиллагааг ойрын хугацаанд хэрэгжүүлэх төлөвлөгөөтэй байна.

Төлөөлөн удирдах зөвлөл



Санжай Гүпта
ТУЗ-ИЙН ДАРГА

ХасБанкны ТУЗ-д: 2017 оноос
Ажлын туршлага: 40 жил



Майкл Мадден
ТУЗ-ИЙН ГИШҮҮН
РОНОК ПАРТНЕРЗ төлөөлөл

ХасБанкны ТУЗ-д: 2009 оноос
Ажлын туршлага: 30 жил



Н. Цэлмүүн
ТУЗ-ИЙН ГИШҮҮН
МОНГОЛЫН АЛТ /МАК/ төлөөлөл

ХасБанкны ТУЗ-д: 2012 оноос
Ажлын туршлага: 20 жил



Б. Уламбаяр
ТУЗ-ИЙН ХАРААТ БУС ГИШҮҮН

ХасБанкны ТУЗ-д: 2015 оноос
Ажлын туршлага: 20 жил



Ив Жако
ТУЗ-ИЙН ГИШҮҮН
КАНАДЫН ҮНДЭСНИЙ БАНК төлөөлөл

ХасБанкны ТУЗ-д: 2016 оноос
Ажлын туршлага: 40 жил



Нираж Вэдва
ТУЗ-ИЙН ХАРААТ БУС ГИШҮҮН

ХасБанкны ТУЗ-д: 2018 оноос
Ажлын туршлага: 30 жил



Анджей Витак
ТУЗ-ИЙН ГИШҮҮН
ЕВРОПЫН СЭРГЭЭН БОСОЛТ
ХӨГЖЛИЙН БАНК төлөөлөл

ХасБанкны ТУЗ-д: 2019 оноос
Ажлын туршлага: 30 жил



Г. Цэвэгжав
ГЗ, ТУЗ-ИЙН ГИШҮҮН
Компанийн дүрмийн 8.27-д заасны дагуу
ТУЗ-ийн гишүүнээр ажилладаг.

ХасБанкны ТУЗ-д: 2019 оноос
Ажлын туршлага: 19 жил



Албертус Браггинк
ТУЗ-ИЙН ГИШҮҮН
ОРИКС КОРПОРАЦИ төлөөлөл

ХасБанкны ТУЗ-д: 2020 оноос
Ажлын туршлага: 30 жил




Сюзанна Херринг Карр
ТУЗ-ИЙН ГИШҮҮН
ОЛОН УЛСЫН САНХҮҮГИЙН
КОРПОРАЦИ төлөөлөл

ХасБанкны ТУЗ-д: 2022 оноос
Ажлын туршлага: 30 жил



Ами Чой
ТУЗ-ИЙН ХАРААТ БУС
ГИШҮҮН

ХасБанкны ТУЗ-д: 2023 оноос
Ажлын туршлага: 25 жил



ТУЗ-ИЙН ХАРААТ БУС ГИШҮҮН
ТУЗ-ийн хараат бус шинэ гишүүн
томилогдожөөр хүлээгдэж байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороод



Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороо нь зохистой засаглалын зарчим, бодлого зэрэг компанийн зохистой засаглалын асуудлыг хариуцаж, нэгдмэл сонирхолтой бүх талын эрх ашигт нийцсэн банкны ил тод, тогтвортой үйл ажиллагаа явуулахад чиглэл өгч, мөн хяналт тавихад шаардагдах бүтэц, процесс бүхий зохистой засаглалын тогтолцоог бүрдүүлж ажиллах үүрэгтэй. Уг хороо нь дараах үндсэн үүрэг хариуцлагатай. Үүнд:

1. ТУЗ-ийн гишүүн болон Гүйцэтгэх захирлын албан тушаалд томилогдох нэр дэвшигчдийг сонгон шалгаруулах, үнэлэх, ТУЗ-д санал болгох;
2. Гүйцэтгэх захирлын ажлын гүйцэтгэлийн үнэлгээ хийж, цалин урамшууллыг тогтоох, хувьцаанд суурилсан урамшууллын хөтөлбөрт хяналт тавих, ТУЗ-ийн цалин урамшууллын талаар ТУЗ-д санал оруулах;
3. Ажилтнуудын зээлийн нөхцөлийг хянах.

Дарга:

Майкл Мадден

Гишүүд:

Нямтайширын Цэлмүүн
Баянсаны Уламбаяр (хараат бус)
Нираж Вэдва (хараат бус)
Ами Чой (хараат бус)



Эрсдэлийн удирдлагын хороо нь эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын зохистой тогтолцоог бүрдүүлж, эрсдэлтэй холбоотой асуудлаар ТУЗ-д зөвлөмж гаргах үүрэгтэй.

Уг хороо нь эрсдэлийн удирдлагын бодлого, бизнесийн чиглэл бүрийн материаллаг эрсдэлийг бууруулах зохистой төлөвлөгөө, эрсдэлийн удирдлагын чиг үүрэг үр дүнтэй байгаа эсэх, эрсдэл хүлээх хязгаар, зээлийн багцын чанар, зээлийг батлах эрх мэдэл, зээлийг сангаас хаах зэрэг саналыг ТУЗ-д танилцуулах үндсэн үүрэг хариуцлагатай.

Дарга:

Ив Жако

Гишүүд:

Албертус Браггинк
Баянсаны Уламбаяр (хараат бус)
Нираж Вэдва (хараат бус)
Ами Чой (хараат бус)



Аудитын хороо нь дотоод хяналтын системийн бүрэн бүтэн, зөв зохистой болон үр дүнтэй байдлыг хянах үүрэгтэй. Уг хороо нь хөндлөнгийн аудиторыг томилох, дахин томилох эсвэл чөлөөлөх, дотоод аудитын газрын ажлын гүйцэтгэл, санхүүгийн тайлагналын шаардлага, заалтуудыг мөрдөж буй эсэх, аудитлагдсан болон аудитлагдаагүй жилийн ба хагас жилийн санхүүгийн тайланг нягталж хянах, их хэмжээний болон сонирхлын зөрчил бүхий хэлцлийг хянах, хууль тогтоомжийн өөрчлөлт ба санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг хянах үндсэн үүрэг хариуцлагатай. Аудитын хороо нь Ерөнхий аудиторыг томилдог ба түүний ажлын гүйцэтгэлийг үнэлдэг.

Дарга:

Баянсаны Уламбаяр (хараат бус)

Гишүүд:

Нираж Вэдва (хараат бус)
Ами Чой (хараат бус)
Анджей Витак
Сюзанна Херринг Карп

Гүйцэтгэх удирдлагын баг

ХасБанканд
ажилласан
дундаж жил

14



Гүмэнжавын Цэвэгжав
ХасБанк болон ТэнГэр Санхүүгийн Нэгдэл
Гүйцэтгэх захирал

ХасБанканд: 2011 оноос
Ажлын туршлага: 19 жил



Ганзоригийн Эрдэнэбаяр
Гүйцэтгэх захирлын тэргүүн орлогч
бөгөөд Санхүү хариуцсан захирал

ХасБанканд: 2005 оноос
Ажлын туршлага: 18 жил



Энзбишийн Уламбаяр
Гүйцэтгэх захирлын орлогч бөгөөд
Иргэдийн банк хариуцсан захирал

ХасБанканд: 2013 оноос
Ажлын туршлага: 23 жил



Бавааны Еркин
Гүйцэтгэх захирлын орлогч бөгөөд
Байгууллагын банк хариуцсан захирал

ХасБанканд: 2002 оноос
Ажлын туршлага: 20 жил



Серикжаны Дауренбек
Гүйцэтгэх захирлын орлогч бөгөөд
Лизинг хариуцсан захирал

ХасБанканд: 2000 оноос
Ажлын туршлага: 25 жил



Илия Аврамов
Эрсдэл хариуцсан захирал

ХасБанканд: 2019 оноос
Ажлын туршлага: 25 жил



Ганзоригийн Зул
Үйл ажиллагаа хариуцсан захирал

ХасБанканд: 1999 оноос
Ажлын туршлага: 24 жил



Хүрэлбаатарын Өнөрбат
Мэдээллийн технологи
хариуцсан захирал

ХасБанканд: 2012 оноос
Ажлын туршлага: 20 жил



Нямсүрэнгийн Мөнхцэлмэг
Хууль хариуцсан захирал / ТУЗ-ийн
нарийн бичгийн дарга

ХасБанканд: 2022 оноос
Ажлын туршлага: 16 жил



Энхбаярын Ундармаа
Ерөнхий Аудитор
/ТУЗ-ийн Аудитын хороонд шууд тайлагнадаг/

ХасБанканд: 2008 оноос
Ажлын туршлага: 25 жил

